169

МОНГОЛЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮН, ӨМГӨӨЛӨГЧ ОТГОНПҮРЭВИЙН ДАВААЖАРГАЛ

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Хот айл оффис. 42 тоот, ӨНБД: 2491, Индекс: .....
Утас: (+976) 88003734, Факс: (+976) .....
E-mail хаяг: **actionlawfirm @gmail.com**

2024.07.31 № Г-07/31

танай _____ -ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

Баянгол, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 12 сарын 09-ний өдрийн 192/ШШ2025/10560 дугаартай шийдвэртэй, иргэн Ц.Болор-Эрдэнийн нэхэмжлэлтэй, Г.Нармандахад холбогдох иргэний хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 сарын 10-ны өдрийн 210/МА2026/01329 дугаартай магадлалыг бүхэлд нь эс хүлээн зөвшөөрч, хүчингүй болгуулах, Баянгол, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 12 сарын 09-ний өдрийн 192/ШШ2025/10560 дугаартай шийдвэрийг хэвээр үлдээлгэхээр нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1-т заасан "шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах", 172.2.2-т заасан "хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн" гэсэн үндэслэлүүдээр дараах үндэслэл бүхий гомдлыг гаргаж байгааг хүлээн авч хянан хэлэлцэж өгнө үү. Үүнд:

Нэг. Шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгуулах тухай:

Анхан шатны шүүхээс тус хэргийн хянан шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 205.1, 206.1, 225.1 дэх заалтыг тус тус үндэслэн, 243.1, 205.1 дэх заалтыг баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байдаг.

Ингэхдээ ИХШХШтХ-ийн 40 дүгээр зүйлд заасан журмын дагуу бодитой, бүх талаас нь харьцуулан үзэж дүгнэж, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлсэн гэж үзэж байна.

Гэтэл Давж заалдах шатны шүүхээс Иргэний хуулийн 496.1, 208.1, 225.4.1 дэх заалтуудыг дүгнэлтээ үндэслэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167.1.4-т заасныг удирдлага болгож нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Ингэхдээ хэргийн бодит үйл баримт, харилцан зөвшөөрсөн хэлцэл, эрх зүйн харилцааны үргэлжилсэн шинж, зохигчдын тайлбар, ноглох баримт зэргийг зөв үнэлж дүгнээгүй байна.

Тайлбарлавал:

1.1. Талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцаа үргэлжилсэн шинжтэй, 1 хэлцэл болох тухай:

1190

Нэхэмжлэгч Ц.Болор-Эрдэнэ болон хариуцагч Г.Нармандах нар нь маргаан бүхий орон сууцыг худалдан борлуулах хэлцэлийн гол нөхцөлийг анхнаасаа төлбөрийг хэсэгчлэн төлөх буюу Зээлээр худалдах, худалдан авахаар зөвшилцсөн байдаг.

Ингэхдээ 1/урьдчилгаа төлбөрийг дараа хуваан төлөх, 2/үлдэх хэсгийг банкны зээлээр санхүүжүүлэх тохиролцоог харилцан хүлээн зөвшөөрч, банкны зээл авахад нь нэхэмжлэгч, хариуцагчид туслалцаа үзүүлсэн байдаг.

Ингэхдээ Г.Нармандах орон сууцны урьдчилгаанд төлөх төлбөр өөрт нь байхгүй тул өөрийн ажиллаж буй компани болох "Грюневалд Монголиа"ХХК-ийн захиран зарцуулах эрхтэй, борлуулалтын орлогыг Ц.Болор-Эрдэнийн дансанд түр байршуулж, банкны зээлийн судалгаанд шаардлагатай баримт бүрдүүлсэн байдаг.

Г.Нармандахын Ц.Болор-Эрдэнэ рүү орон сууц худалдан авах урьдчилгаанд 2023 оны 06 сарын 15-ны өдөр шилжүүлсэн гэх 105,000,000 төгрөг нь түүний ***захиран зарцуулах эрхгүй, гуравдагч компанийн орлого байсан*** гэдэг нь хавтаст хэргийн ***29-37 дугаар талд авагдсан*** Г.Нармандахын ***Хаан банкны 5005936243 дугаартай дансны хуулгаар*** гуравдагч иргэн, хуулийн этгээдүүдээс чипсны орлогууд орсон, хариуцагчийн чипсны худалдаа хийдэг гэх тайлбараар нотлогдоно.

Хариуцагч нь "Грюневалд Монголиа"-ХХК-руу 300,000,000 гаруй төгрөгийн борлуулалтын орлогыг шилжүүлэн өгөх үүрэгтэй байсан гэдэг нь ***хэргийн 76 дугаар талд авагдсан*** тус компанийн албан бичиг, мөн хариуцагчийн өөрийнх нь шүүхэд гаргасан тайлбараар мөн нотлогддог.

Хэргийн 27 дугаар талд авагдсан хариуцагч Г.Нармандахын Худалдаа хөгжлийн банкны 474047650 дугаартай дансны хуулгаар 2023 оны 06 сарын 15-ны өдөр өөрийн Хаан банкны 5005936243 дугаартай данснаас 100,000,000 төгрөгийг "2023 оны 05 сараас 6 сар хүртэлх ашиг" гэсэн утгаар шилжүүлэн авсан байгаа нь ***өөрийн захиран зарцуулах эрхгүй "Грюневалд Монголиа"-ХХК-ийн мөнгийг урьдчилгаа төлсөн мэтээр харуулахаар дүр үзүүлэн*** өөрийн данс хооронд шилжүүлж, Ц.Болор-Эрдэнэ рүү шилжүүлсэн байгааг нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагадаа анхнаасаа дурдаж, баримтаар нотлогдсон байгааг Г.Нармандах үгүйсгэсэн баримтыг хэрэгт огт гаргаж өгөөгүй.

Зохигчид орон сууцны урьдчилгаа төлбөр төлөгдөөгүй, "Грюневалд Монголиа"-ХХК-ийн захиран зарцуулах эрхтэй мөнгөн хөрөнгийг дансаараа дамжуулж гаргаж байгаа, нэхэмжлэгчийн өөрийн захиран зарцуулах эрхэд ирээгүйг ойлгож, ухамсарлаж байсан учраас хожим "Грюневалд Монголиа"-ХХК-руу дамжуулж шилжүүлсэн байтал Давж заалдах шатны шүүхээс орон сууц худалдах, худалдан авах харилцаа дуусгавар болсны дараа нэхэмжлэгч сайн дураар хариуцагчийн "Грюневалд Монголиа"-ХХК-д төлөх ***"өр төлбөрийг сайн дураар төлсөн" эрх зүйн үүсдаа 2 дахь харилцаа үүссэн мэтээр огт үндэслэлгүй дүгнэж, хууль тогтоомжийг буруу тайлбарлаж*** хэрэглэсэн.

Нэхэмжлэгч Ц.Болор-Эрдэнэ нь хариуцагч Г.Нармандах болон бусад хэний ч өр төлбөрийг түүний өмнөөс, ямар ч хариу төлбөргүйгээр төлөх баян цагалан эсхүл буян нь дэлгэрсэн, бурхан шиг хүн гэж дүгнэх нотлох баримт, үндэслэл хэрэгт байхгүй болно.

Хэрэв дээрх нөхцөл байдлыг нотлох баримт хэрэгт авагдаагүй, дүгнэлт гаргах боломжгүй тохиолдолд шүүх хариуцагчийн давж заалдах гомдлын дагуу хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах, уг асуудлыг тодруулах боломжтой байсан.

Учир нь орон сууцны урьдчилгаа 110,000,000 *төгрөгийг Г.Нармандах төлөөгүй, төлөхийг* нэхэмжлэгч Ц.Болор-Эрдэнэ Viber мэссэжээр шаардаж байсан үйл баримт байгаа талаар дурдсан байдаг.

Харин нэхэмжлэгч нь өөрийн утсаа гээгдүүлж, харилцаж байсан viber зурвасаа сэргээж чадахгүй хүндэтгэх шалтгаан байсан боловч давж заалдах журмаар хэргийг хэлэлцсэнээс хойш viber зурвасыг олж, сэргээсэн байгаа болно.

Хоёр. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлийн тухай

Түс хэргийг анхан шатны журмаар 2025 оны 12 сарын 09-ний өдөр хянан шийдвэрлэж, шийдвэр бичгээр албажиж гарснаас хойш Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хаягаар 2026 оны 01 сарын 27-ны өдөр хүргүүлж, 2026 оны 02 сарын 10-ны өдөр давж заалдах гомдол гаргах хугацаа дууссанаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 192/ШЗ2026/14991 дугаартай ***"Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай" захирамж, 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 192/ШЗ2026/01604 дугаартай Гүйцэтгэх хуудас гарч,*** шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байсан.

Гэтэл анхан шатны шүүхээс харнуцагч Г.Нармандахын давж заалдах гомдол гаргах хугацаа дуусаж, 3 сар гаруй хугацаа өнгөрсны дараа, хугацаа сэргээлгэх тухай хүсэлтийг хүлээн авч хүндэтгэн үзэх шалтгааныг нотлох ЯМАРЧ НОТЛОХ БАРИМТГҮЙГЭЭР, ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР сэргээж, ХЭРГИЙН НЭГ ТАЛД ИЛТ НОЦТОЙГООР ҮЙЛЧИЛЖ, ДАВУУ БАЙДАЛ ОЛГОСОН, шүүх хөндлөнгийн байх, хууль, нотлох баримтад үндэслэж, үндэслэл бүхий шийдвэр гаргах зарчмыг огт баримтлаагүй байдаг.

Тодруулбал:

ИХШХШтХ-ийн 120 дугаар зүйлийн 120.3-т "Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 120.2-т заасан ***ХУГАЦААГ ХҮНДЭТГЭН ҮЗЭХ ШАЛТГААНААР ХЭТРҮҮЛСЭН*** бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах ба хүсэлтийг ***хангах эсэхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ***" гэж заасан бөгөөд Г.Нармандах нь хүндэтгэх шалтгааныг огт нотлоогүй, ийм үйл баримт байхгүй байна.

Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 07 сарын 03-ны өдрийн 33-р тогтоолоор тайлбарласан тайлбарын 28-т "Хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3.-т заасан ***"хүндэтгэн үзэх шалтгаан" гэдэгт*** энэ зүйлд заасан хугацааны дотор гомдол гаргагч ***хүндээр өвчилсөн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон*** зэрэг ***өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар гомдол гаргах боломжгүй байсан*** байдлыг ойлгоно. Харин хууль мэдэхгүй явдал нь хүндэтгэн үзэх шалтгаан болохгүй" гэж тайлбарласан байдаг ба шүүхийн практикт мөн адил хүндэтгэх шалтгааныг дээрх нөхцөл байдлаар тайлбарлаж хэрэглэдэг.

Гэтэл Г.Нармандах нь итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Бат-Өлзий түүнд шүүх хуралдааны тов, шийдвэр зэргийг мэдэгдээгүй, шүүх хуралдаанд оролцоогүй гэсэн байдаг.

Гэтэл Г.Нармандах Ц.Бат-Өлзийд хандаж ***мэдээлэл хүссэн эсэх, түүнд нь хариу өгөөгүй эс үйлдэхүй байсан эсэх***, харилцаа холбооны бусад хэрэгсэл, гар утсаар ***холбогдох боломжгүй байсан эсэх***, өмгөөлөгч утасны ***дугаараа өөрчилсөн, хаагдсан байсан эсэх***, итгэмжлэгдсэн төлөөлөгч холбогдохгүй нөхцөлд ***шүүхэд өөрөө ирж хандсан эсэх, хандах боломжгүй байсан*** эсэх зэргээ огт нотлоогүй байна.

Түүнчлэн ***өмгөөлөгчийн үүрэгээ гүйцэтгэхгүй төрлийг*** МӨХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороо зэрэг эрх бүхий байгууллагад ***гомдол гаргаж, тогтоолгосон эсэх,*** хариуцлага тооцсон эсэх үйл баримт огт байхгүй, нотлоогүй болно.

Иймд ИХШХШтХ-ийн 120 дугаар зүйлийн 120.3-т заасан заалтыг нотлох баримтгүйгээр, үндэслэлгүй хэрэглэж, хэргийн нэг оролцогч талд илт үйлчилсэн, давуу байдал олгосон, ноцтой зөрчил гарсан нь хэргийн шийдвэрт нөлөөлсөн байна.

Мөн Давж заалдах шатны шүүх хуралдааны өмнө Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 4-р давхарт зөвхөн шүүгч нарын ашигладаг 00-ын өрөөнд хариуцагч Г.Нармандах нь орж, шүүх бүрэлдэхүүний нэг шүүгч араас нь орсон үйл баримт нь шүүгч хэргийн аль нэг талтай ганцаарчлан уулзахгүй байх, шүүх хөндлөгийн байх, нөлөөнд автахгүй байх нөхцөл байдал алдагдсан, энэ нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзэх, хардах шууд үндэслэл болж байна.

Гурав. Шүүхийн шийдвэрийг албан ёсоор гардуулсан тухай:

Тус шүүхийн шийдвэр бичгээр гарч нэхэмжлэгч гардаж авснаас хойш Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хаягаар 2026 оны 01 сарын 27-ны өдөр хүргүүлсэн байх ба гардуулсан тухай шуудангийн албан ёсны тэмдэг дарагдаж баталгаажсан. Хугацаа тоолох журмын дагуу 2026 оны 02 сарын 10-ны өдөр гомдол гаргах хугацаа дууссанаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

ИХШХШТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Иргэн өөрийн биеэр буюу ***төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэхэд оролцоно***" гэж заасны дагуу Г.Нармандах нь тус хэргийг хянан шийдвэрлэх хугацаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Анандаас татгалзаж, 2 дахь удаагаа Ц.Бат-Өлзийд нотариатаар батлуулан итгэмжлэл олгож, өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцуулж байсан бөгөөд мөн хуулийн ***25, 26-р зүйлд заасан бүх бүрэн эрхийг олгосон*** байсан.

Анхан шатны Шүүхээс мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-д "зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчид шаардлага ба татгалзлаа үндэслэж буй нотлох баримтаа өөрөө гаргаж нотлох ***үүрэгтэйг танилцуулж***, ***эдлэх эрхийг*** нь ***тайлбарлан өгөх***" гэж заасны дагуу эрх, үүргийг бүрэн тайлбарлаж, сануулж өгсөн.

Хариуцагчийн төлөөлөгч нь шүүх хуралдааны товыг мэдэгдсэн ч удаа дараа шүүх хуралдаа ирж оролцоогүй байдаг бөгөөд 2 дахь удаагаа ирээгүй тул эзгүйд шийдвэрлэсэн.

ИХШХШТХ-ийн 119 дүгээр зүйлийн 119.4-т "Шүүх хуралдаанд оролцсон тал энэ хуулийн 119.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш ***14 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж шийдвэрийг өөрөө гардан авна***", 119.5-д "***Хэргийг зохигчийн оролцоогүйгээр шийдвэрлэсэн бол*** шүүх шийдвэрийг энэ хуулийн ***119.4-т заасан хугацаанд зохигчид гардуулна.*** Ийнхүү гардуулах боломжгүй бол шүүх уг хугацаа өнгөрснөөс хойш ***7 хоногийн дотор зохигчийн оршин суугаа /оршин байгаа/ газар*** болон ажилладаг байгууллагын нь аль нэг ***хаягаар баталгаат шуудангаар,*** эсхүл шүүхийн ажилтнаар ***хүргүүлнэ***" 119.6-д "Энэ хуулийн ***119.5-д заасны дагуу хүргүүлснийг гардан авсанд тооцох*** бөгөөд шүүхийн шийдвэрийг хүргүүлэхдээ энэ хуулийн 77.6-д заасан журмыг баримталж болно" гэж тус тус заасан.

ИХШХШтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1-т "***Зохигч***, гуравдагч этгээд, түүнчлэн энэ хуулийн 12.1.2-12.1.4-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа этгээдийг ***хэргийн оролцогч гэнэ***", 25 дугаар зүйлийн 25.2-т "Хэргийн оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараахь үүрэг хүлээнэ", 25.2.3-т "***шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх***" 25.2.6-т "***шүүхийн шийдвэрийг гардаж авах***, биелүүлэх" гэж тус тус заасан.

Иймд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид шүүх хуралдааны товыг мэдэгдэж, шүүхийн шийдвэрийг мэдэгдэж, шуудангаар хүргүүлснийг хариуцагчид шүүхийн шийдвэрийг гардуулсан гэж үзэх бөгөөд хариуцагч өөрөө болон төлөөлөгч нарын хэн аль нь шүүх хуралдааны товыг лавлах, ***шүүхийн шийдвэрийг гардаж авах хуульд заасан үүрэгтэй, энэ талаар мэдэж байсан***.

Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн 2023 оны 04 сарын 14-ний өдрийн 17 дугаартай тогтоолоор 5.3 дах хэсэгт "Шүүх хуралдаанд оролцоогүй хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид шүүх шийдвэр, магадлалыг гардан авахыг мэдэгдэх ба мэдэгдсэний дагуу ирж авсан бол гардуулсан гэж үзэж, гомдол гаргах хугацааг тухайн өдрөөс тоолно. Харин

мэдэгдсээр байтал ирж аваагүй бол Хуулийн 119 дүгээр зүйлийн 119.4-т заасан хугацаа өнгөрсөн өдрөөс, *шүүх мэдэгдэх боломжгүй тохиолдол үүссэн бол баталгаат шуудангаар*, эсхүл шүүхийн ажилтнаар хүргүүлж, *хүргэсэн талаар баталгаажуулсныг гардан авсанд тооцохыг* ялгамжтай байдлаар тайлбарлав.

Түүнээс гадна нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, эсхүл хариуцагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, эсхүл гуравдагч этгээд, түүний төлөөлөгч, өмгөөлөгч *аль нэг талд байгаа этгээд шийдвэрийг өөр өөр цаг хугацаанд гардан авах тохиолдол бий*. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд *зохигч*, гуравдагч этгээд өөрөө, *эсхүл тэдгээрийг итгэмжлэл*, гэрээний *үндсэн дээр төлөөлж, өмгөөлж оролцож байгаа төлөөлөгч*, өмгөөлөгч нь *хоорондоо нэгдмэл ашиг сонирхолтой тул* нэгдмэл ашиг сонирхолтой нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, тэдгээрийн *хэн нь эхэлж гардан авсан огнооноос* тухайн талын давж заалдах болон хяналтын журмаар *гомдол гаргах хугацааг тоолно"* гэж тус тус тайлбарласан.

Иймд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид шүүхийн шийдвэрийг шуудангаар илгээж, гардуулсаныг буруутгах үндэслэлгүй бөгөөд шуудангаар шийдвэрийг илгээж, хүлээж авсан байх тул гардаж авснаар тооцож, хариуцагчийн давж заалдах гомдол гаргах хугацааг тоолох, гомдол гаргах хугацаа дууссан буюу Давж заалдах шатны шүүх хариуцагчийн гаргасан гомдлыг анхнаасаа хүлээн авах, хэлэлцүүлэх хууль зүйн үндэслэлгүй байсан гэдгийг харуулж байна.

Иймд хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцүүлж Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 сарын 10-ны өдрийн 210/МА2026/01329 дугаартай магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, Баянгол, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 12 сарын 09-ний өдрийн 192/ШШ2025/10560 дугаартай шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү.

ГОМДОЛ ГАРГАСАН

ӨМГӨӨЛӨГЧ О.ДАВААЖАРГАЛ

ИТГЭМЖЛЭГДСЭН

ТӨЛӨӨЛӨГЧ Б.МӨНХ-УНДРАЛ